

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/76/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дундговь аймаг 2026 он	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn Аудитын менежер: Т.Батсайхан Утас: 70592225 Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Угтахбаяр Утас: 70593113 Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn Аудитор: Б.Сарангуа Утас: 70593113 Цахим хаяг: Saranguab@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	
/төгрөгөөр/.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	
/төгрөгөөр/.....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	
/төгрөгөөр/.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
/төгрөгөөр/.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Албан шаардлага.....	10
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГА Б.ӨЛЗИЙБАЯР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дундговь аймгийн Биеийн тамир спортын газар нь 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар жилийн эцсийн тооллогыг хуулийн дагуу хийж, баталгаажуулж санхүүгийн тайлан гаргаагүй зэрэг 370,814.7 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 31.6 дахин их байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.3-г заасан заалтуудтай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад төсвөөс олгох санхүүжилтийг 65.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь өмнөх оноос цалин хөлс болон нэмэгдэл урамшил, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, зардлууд өссөнтэй холбоотой байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал

4826050111

гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

Бусад асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт, 36 арга хэмжээг хэрэгжүүлж, аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 98.2 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР.



Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

<i>/төгрөгөөр/</i>			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,876,949.80	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,876,949.80	-
31210	Төгрөг	1,876,949.80	-
31218	Ахмадын сангийн харилцах	1,876,949.80	-
33	АВЛАГА	60,840.10	2,749,108.39
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	2,748,749.80
33500	Бусад авлага	60,840.10	358.59
33510	Байгууллагаас авах авлага	60,840.10	358.59
35	БАРАА МАТЕРИАЛ	121,049,785.84	91,371,335.84
35100	Түүхий эд материал	61,793,315.84	42,579,595.84
35110	Тусгай зориулалттай материал	61,793,315.84	42,579,595.84
35400	Хангамжийн материал	59,256,470.00	48,791,740.00
35410	Бичиг хэргийн материал	2,815,950.00	2,132,000.00
35420	Аж ахуйн материал	49,550,670.00	43,809,890.00
35440	Түлш, шатах тослох материал	4,040,000.00	-
35450	Барилгын засварын материал	2,849,850.00	2,849,850.00
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	122,987,575.74	94,120,444.23
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,839,930,375.31	4,138,957,366.58
39200	Биет хөрөнгө	2,803,559,041.78	3,103,308,366.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,267,789,501.76	3,287,604,701.76
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(599,772,182.91)	(597,718,535.31)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,600,000.00	33,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(25,200,000.18)	(30,800,000.22)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	122,787,367.00	124,849,347.00
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(51,391,007.59)	(59,885,633.48)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	118,386,849.34	118,981,023.84
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(62,641,485.64)	(29,162,537.06)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	255,840,000.00
39300	Биет бус хөрөнгө	1,036,371,333.53	1,035,649,000.05
39301	Програм хангамж	2,453,000.00	2,013,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(1,257,666.47)	(1,539,999.95)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,035,176,000.00	1,035,176,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	3,839,930,375.31	4,138,957,366.58
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	3,962,917,951.05	4,233,077,810.81
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	849,522.82
41300	Өглөг	-	849,522.82
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	849,522.82
41311	Цалингийн өглөг	-	47,311.73
41313	ХАОАТ-ын өглөг	-	802,211.09
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	-	849,522.82
51	Засгийн газрын хувь оролцоо	3,962,917,951.05	4,232,228,287.99
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,020,878,143.04	1,020,878,143.04
511001	Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан	1,020,878,143.04	1,020,878,143.04
51200	Хуримтлагдсан үр дүн	2,341,020,643.12	2,617,427,151.06
51210	Өмнөх үеийн үр дүн	2,444,079,169.12	2,348,116,814.12
51220	Тайлант үеийн үр дүн	(103,058,526.00)	269,310,336.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	601,019,164.89	593,922,993.89
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	3,962,917,951.05	4,232,228,287.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	3,962,917,951.05	4,233,077,810.81

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

<i>/төгрөгөөр/</i>			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	957,216,171.18	994,710,005.10
1310	Улсын төсвөөс	591,878,000.00	612,412,600.00

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	591,878,000.00	612,412,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	89,182,371.18	60,825,805.10
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	82,187,871.18	57,704,055.10
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,994,500.00	3,121,750.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	276,155,800.00	321,471,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	276,155,800.00	321,471,600.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	39,418,000.00	442,902,962.30
1200	Нийтлэг татварын бус орлого	39,418,000.00	442,902,962.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	7,691,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	-	7,691,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	435,211,162.30
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	39,418,000.00	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	996,634,171.18	1,437,612,967.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,095,060,637.18	1,168,302,630.46
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,048,723,588.50	1,121,243,156.39
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	394,762,271.65	505,740,276.73
210101	Үндсэн цалин	245,185,709.58	278,952,661.64
210102	Нэмэгдэл	103,282,715.88	153,194,105.82
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	35,429,999.59	43,356,000.00
210104	Урамшуулал	10,863,846.60	30,237,509.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,721,727.05	60,281,306.48
210201	Тэтгэврийн даатгал	34,339,416.70	42,320,212.53
210202	Тэтгэмжийн даатгал	4,008,451.08	4,985,923.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,146,842.30	2,475,141.66
210204	Ажилгүйдлийн даатгал	1,645,403.18	2,100,005.81
210205	Эрүүл мэндийн даатгал	6,581,613.79	8,400,023.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	255,574,834.50	274,208,668.15
210301	Гэрэл, цахилгаан	8,345,317.50	10,066,059.44
210302	Түлш, халаалт	242,927,105.00	260,655,780.00
210303	Цэвэр, бохир ус	4,302,412.00	3,486,828.71
2104	Хангамж, бараа материалын зардал	4,767,698.00	16,845,716.00
210401	Бичиг хэрэг	879,540.00	1,911,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,145,540.00	5,340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	910,800.00	803,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	62,208.00	34,560.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,769,610.00	8,648,856.00
210408	Бараа материал актласны зардал	-	108,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,860,900.00	20,035,000.00
210604	Урсгал засвар	12,860,900.00	20,035,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,844,760.00	630,000.00
210701	Гадаад албан томилолт	1,418,760.00	-
210702	Дотоод албан томилолт	426,000.00	630,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,132,470.00	17,640,148.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,411,300.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	686,700.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	490,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	46,600.00	141,358.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	1,024,870.00	17,058,790.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	325,058,927.30	225,862,041.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	176,467,104.00	87,318,070.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	148,591,823.30	138,543,971.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,337,048.68	47,059,474.07

2132	Бусад урсгал шилжүүлэг	8,884,100.00	200,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	6,137,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,746,800.00	200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,164,943.18	23,694,692.22
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,327,403.18	21,737,480.26
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,837,540.00	1,957,211.96
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,288,005.50	23,164,781.85
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,288,005.50	23,164,781.85
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,095,060,637.18	1,168,302,630.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(98,426,466.00)	269,310,336.94
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(98,426,466.00)	269,310,336.94

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	957,216,171.18	994,710,005.10
1310	Улсын төсвөөс	591,878,000.00	612,412,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	591,878,000.00	612,412,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	89,182,371.18	60,825,805.10
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	82,187,871.18	57,704,055.10
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,994,500.00	3,121,750.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	276,155,800.00	321,471,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	276,155,800.00	321,471,600.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	-	7,691,800.00
1200	Нийтлэг татварын бус орлого	-	7,691,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	7,691,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	-	7,691,800.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	957,216,171.18	1,002,401,805.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	960,578,171.18	1,001,918,954.90
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	914,241,122.50	952,110,731.03
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	394,734,662.95	504,830,272.40
210101	Үндсэн цалин	237,615,097.94	278,042,657.31
210102	Нэмэгдэл	103,282,715.88	153,194,105.82
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	35,429,999.38	43,356,000.00
210104	Урамшуулал	18,406,849.75	30,237,509.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,721,727.05	60,281,306.48
210201	Тэтгэврийн даатгал	34,339,416.70	42,320,212.53
210202	Тэтгэмжийн даатгал	4,008,451.08	4,985,923.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,146,842.30	2,475,141.66
210204	Ажилгүйдлийн даатгал	1,645,403.18	2,100,005.81
210205	Эрүүл мэндийн даатгал	6,581,613.79	8,400,023.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	255,602,834.50	274,208,668.15
210301	Гэрэл, цахилгаан	8,345,317.50	10,066,059.44
210302	Түлш, халаалт	242,927,105.00	260,655,780.00
210303	Цэвэр, бохир ус	4,330,412.00	3,486,828.71
2104	Хангамж, бараа материалын зардал	9,154,758.00	3,641,386.00
210401	Бичиг хэрэг	2,454,740.00	1,220,350.00
210402	Тээвэр, шатахуун	2,445,540.00	800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	910,800.00	803,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	62,208.00	34,560.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,281,470.00	783,476.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,464,960.00	24,098,150.00
210604	Урсгал засвар	17,464,960.00	24,098,150.00
2107	Томилолт, зочны зардал	1,844,760.00	630,000.00
210701	Гадаад албан томилолт	1,418,760.00	-
210702	Дотоод албан томилолт	426,000.00	630,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,132,470.00	17,640,148.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,411,300.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	686,700.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	490,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	46,600.00	141,358.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	1,024,870.00	17,058,790.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	181,584,950.00	66,780,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	181,584,950.00	66,780,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,337,048.68	49,808,223.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,884,100.00	200,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	6,137,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,746,800.00	200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,164,943.18	26,443,442.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,327,403.18	24,486,230.06
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,837,540.00	1,957,211.96
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,288,005.50	23,164,781.85
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,288,005.50	23,164,781.85
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	960,578,171.18	1,001,918,954.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	(3,362,000.00)	482,850.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,498,000.00	2,359,800.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	1,498,000.00	2,359,800.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	1,498,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,498,000.00	2,359,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,498,000.00	2,359,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(1,498,000.00)	(2,359,800.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	(4,860,000.00)	(1,876,949.80)
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,736,949.80	1,876,949.80
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,876,949.80	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,020,878,143.04	601,019,164.89	2,439,447,109.12	4,061,344,417.05
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,020,878,143.04	601,019,164.89	2,439,447,109.12	4,061,344,417.05
4	Тайлант үеийн үр дүн	-	-	(98,426,466.00)	(98,426,466.00)

5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,020,878,143.04	601,019,164.89	2,341,020,643.12	3,962,917,951.05
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	7,096,171.00	7,096,171.00
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,020,878,143.04	601,019,164.89	2,348,116,814.12	3,970,014,122.05
8	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(7,096,171.00)	-	(7,096,171.00)
9	Тайлант үеийн үр дүн	-	-	269,310,336.94	269,310,336.94
10	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,020,878,143.04	593,922,993.89	2,617,427,151.06	4,232,228,287.99

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
12	Татварын бус орлого	644,062,000.00	598,366,919.74	44,567,680.26
12000	Нийтлэг татварын бус орлого	5,000,000.00	7,691,800.00	(2,691,800.00)
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	5,000,000.00	7,691,800.00	(2,691,800.00)
12200	Тусламжийн орлого	637,934,600.00	590,675,119.74	47,259,480.26
122005	Төсвөөс санхүүжих	637,934,600.00	590,675,119.74	47,259,480.26
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	644,062,000.00	598,366,919.74	44,567,680.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	644,062,000.00	595,675,119.74	47,259,480.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	632,012,400.00	595,475,119.74	35,409,880.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	492,259,400.00	475,313,915.69	16,945,484.31
210101	Үндсэн цалин	262,939,000.00	278,042,657.31	(15,103,657.31)
210102	Нэмэгдэл	149,985,300.00	123,677,749.11	26,307,550.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,905,900.00	43,356,000.00	1,549,900.00
210104	Урамшуулал	34,429,200.00	30,237,509.27	4,191,690.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,501,600.00	56,710,920.05	4,790,679.95
210201	Тэтгэврийн даатгал	41,863,800.00	39,810,994.91	2,052,805.09
210202	Тэтгэмжийн даатгал	4,925,800.00	4,690,721.15	235,078.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,461,300.00	2,327,540.61	133,759.39
210204	Ажилгүйдлийн даатгал	2,450,100.00	1,976,332.67	473,767.33
210205	Эрүүл мэндийн даатгал	9,800,600.00	7,905,330.71	1,895,269.29
2104	Хангамж, бараа материалын зардал	9,916,500.00	3,641,386.00	6,275,114.00
210401	Бичиг хэрэг	1,437,000.00	1,220,350.00	216,650.00
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	800,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,989,400.00	803,000.00	2,186,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,195,000.00	34,560.00	1,160,440.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,495,100.00	783,476.00	2,711,624.00
2107	Томилолт, зочны зардал	630,000.00	630,000.00	-
210702	Дотоод албан томилолт	630,000.00	630,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	22,850,000.00	17,640,148.00	5,209,852.00
210803	Даатгалын үйлчилгээ	497,700.00	-	497,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	497,700.00	141,358.00	356,342.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	79,600.00	-	79,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	997,400.00	440,000.00	557,400.00
210807	Нийтлэг үйлчилгээний төлбөр хураамж	20,777,600.00	17,058,790.00	3,718,810.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,854,900.00	41,538,750.00	2,188,750.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,854,900.00	41,538,750.00	2,188,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,049,600.00	200,000.00	11,849,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	11,849,600.00	-	11,849,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	200,000.00	-
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,691,800.00	(2,691,800.00)
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,691,800.00	(2,691,800.00)
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-
12100	Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл	-	-	-
12200	Кассын дансны эцсийн үлдэгдэл	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)	60,825,805.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,825,805.10
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58,868,593.14
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	29,516,356.71
210102	Нэмэгдэл	29,516,356.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,570,386.43
210201	Тэтгэврийн даатгал	2,509,217.62
210202	Тэтгэмжийн даатгал	295,202.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	147,601.05
210204	Ажилгүйдлийн даатгал	123,673.14
210205	Эрүүл мэндийн даатгал	494,692.51
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,781,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,781,850.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,957,211.96
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,957,211.96
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,957,211.96
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)	60,825,805.10
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	60,825,805.10
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,825,805.10
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	57,704,055.10
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,121,750.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
11000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
12000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 397,603.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 26,788.8 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 370,814.7 мянган төгрөгийн албан шаардлагыг хүргүүллээ.

Залруулсан алдаа:

Аудитаар нийт 26,788.8 мянган төгрөгийн зөрчил илэрч, аудитын явцад бүрэн залрууллаа. Үүнд:

- Үндсэн хөрөнгө бэлтгэсэн 2,359.8 мянган төгрөгийн зардлыг биет бус хөрөнгө бэлтгэсэн зардлаар тайлагнаагүй алдаа нь иж бүрэн байх батламж мэдэгдлийг;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд 21,737.2 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг илүү тайлагнасан алдаа нь иж бүрэн байх батламж мэдэгдлийг;
- Санүүгийн байдлын тайланд 2,691.8 мянган төгрөгийн авлагыг дутуу тайлагнасан алдаа нь иж бүрэн байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 370,814.7 мянган төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлагыг хүргүүлээ.

3.1 Албан шаардлага

Жилийн эцсийн 370,814.7 тооллогыг хуулийн дагуу хийж, баталгаажуулж санхүүгийн тайлан гаргаагүй Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т (*Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*), 20.2.6-т (*Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*), Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т (*Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана*), 73.2 (*Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана*) заасныг зөрчсөн ба иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 93% хувийг залруулагдаагүй, 7% хувийг залруулсан алдаа эзэлж байна. Нийт 370,814.7 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитын асуудал байна. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 370,814.7 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 31.6 дахин их байгаа тул “ХЯЗГААРЛАЛТГАЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгө бэлтгэсэн зардлыг биет бус хөрөнгө бэлтгэсэн зардлаар тайлагнаагүй	1	2,359.8			1	2,359.8	1	2,359.8		
Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг илүү тайлагнасан	1	21,737.2			1	21,737.2	1	21,737.2		
Санхүүгийн байдлын тайланд авлагыг дутуу тайлагнасан	1	2,691.8	1	2,691.8			1	2,691.8		
Дүн	3	26,788.8	1	8.135.3	2	24,097.03	3	26,788.8		

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жилийн эцсийн тооллогыг хуулийн дагуу хийж, баталгаажуулж санхүүгийн тайлан гаргаагүй	1	370,814.7			1	370,814.7				
Дүн	1	370,814.7			1	370,814.7				